



## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

### Бие бялдарын хөгжилт чийрэгжилтийн сорил авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 053 дугаар зарлигийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Их дээд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд байгууллагын багш, ажилтан, оюутан, сурагчид, хүүхдүүдээс, өрхийн эрүүл мэндийн төвүүд тус бүр хороодын 1000 иргэдээс Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах ажлыг зохион байгуулж онлайн бүртгэлээр шивж оруулан нэгдсэн дүн мэдээг Биеийн тамир спортын хороонд 2017 оны 04 дүгээр сарын 3-наас 05 дугаар сарын 31-ний дотор ирүүлэхийг үүрэг болгосугай.
2. “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, төрийн байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан албан хаагчдаас авах хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сорил авах багт оролцож байгаа биеийн тамирын багш нарыг 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 13-ны өдөр хүртэл ажлаас чөлөөлөхийг холбогдох сургуулиудын захирлуудад даалгасугай.
4. Сорилын тайлан мэдээг хугацаанд нь гаргаж Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын яаманд хүргүүлэхийг дүүргийн Биеийн тамир спорт хороо \С.Эрдэнэбат\-д үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Баясах/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВДАВАА

1130200386